

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
эрдэм шинжилгээний бичиг

Боть ХХХХ (463)

2016

(157-162)

МУИС-ИЙН УТГА ЗОХИОЛ СУДЛАЛ ХӨТӨЛБӨРИЙН БАКАЛАВРЫН
СУДАЛГААНЫ АЖЛЫН ЧИГЛЭЛИЙГ ТОДОРХОЙЛОХ НЬ

/2006-2016 он/

Г. Нарангунгалаг *

Товч агуулга: Энэ судалгаагаар Монгол улсын их сургуулийн утга зохиол хөтөлбөрийн 2006-2016 онд бакалаврын диплом хамгаалсан ажлуудын хандлагыг тодруулж, судалгааны чиглэлийг тодруулна.

Түлхүүр үг: Утга зохиол судлал, судалгааны цар хүрээ, бакалаврын диплом


Монгол Улсын Их Сургууль 1942 онд байгуулагдсанаас хойш утга зохиол, урлаг судлалын тэнхим 1981 онд “Улсын дээд, тусгай дунд, техник мэргэжлийн боловсролын хорооны [УДТДТМБХ] 1981 оны 245/36 дугаар тогтоол гарч, Монгол хэл-зохиолын тэнхимээс Монголын утга зохиолын тэнхим өрх тусгаарлан анх байгуулагдсан билээ.”¹ Үүнээс хойш тус тэнхим “Утга зохиол, сэтгүүл зүйн тэнхим”, “Утга зохиолын тэнхим”, “Нүүдлийн соёл иргэншил судлалын төв” нэртэйгээр үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж 2002-2006 онд “Утга зохиол судлал” ангийг нээсэн бөгөөд анхны төгсөлтөөс хойш даруй арван жилийг үджээ.

Энэ хугацаанд нийт 108 оюутан бакалаврын судалгааны ажил бичиж хамгаалсан бөгөөд ажлын сэдвийн агуулгыг ажиглахад аман зохиол, эртний уран зохиол, орчин үеийн уран зохиол, хүүхдийн уран зохиол, шүүмж судлал, уран зохиолын дидактик, сэтгүүл зүй гэж ерөнхийд нь ангилан үзэж болно. Ажлын агуулгын 25,9 хувь нь аман зохиол, 8,3 хувийг эртний уран зохиол, 27,7 хувийг орчин үеийн монголын уран зохиол, 25 хувийг сэтгүүл зүй, 4,6 хувийг хүүхдийн уран зохиол, шүүмж судлал 5,5 хувь, дидактик 1,8 хувийг эзэлж байна.


Бид бакалаврын судалгааны ажлыг бүтцээр буюу төрөл зүйлээр ангилан үзсэнээр судалгааны чиглэлийг тодорхойлохын зэрэгцээ цаашид хийгдэх шаардлагатай салбар хийгээд тулгамдаж буй асуудлыг тодорхойлох зорилготой.

* Монгол Улсын Их Сургууль, Утга зохиол, урлаг судлалын тэнхим

¹ Дулам.С., “Эрдэм цогцолсон гучин жил” (дурсамж), “Утга зохиол-30” УБ., 2012, 3 дугаар тал




Дээрхээс харахад утга зохиол судлал хөтөлбөрийн судалгааны дийлэх нь аман зохиол, орчин үеийн уран зохиолын чиглэлд хамаарч буй нь харагдаж буй бөгөөд сэтгүүл зүйн судалгааны ажил сүүлийн жилүүдэд эрчимтэй өсжээ.



1. Аман зохиол судлал

Аман зохиол судлалын хувьд төрөл зүйлийн судалгаа голлох байр эзэлж байна. Үүнээс аман яруу найргийн судалгаанаас аялгуут бус аман яруу найраг, хүүрнэн өгүүлэх аман зохиолын судалгаанаас түүх, домгийн өгүүлэмжийн судалгаа голлон

хийгдсэн байна. Мөн бэлгэдэл зүй, монгол утга соёл, зан үйлийн аман зохиолын судалгаа зохих түвшинд хийгдсээр байна.



2. Эртний уран зохиол


Эртний уран зохиол судлалын чиглэлээр энэ хугацаанд найман ажил бичигдсэнээс Монголын нууц товчооны дүр дүрслэлтэй холбоотой хоёр ажил, “Чингисийн хоёр эр загалын тууж адгуусны туультай холбогдох нь” гэснээс бусад нь XIX зууны монголын уран зохиолын судалгаа байна. Дээрхээс харахад дундад зууны уран зохиолын судалгаа хийгдээгүй аж.

№		Оюутны нэр	Сэдэв
2005-2006			
2	1	Сарангэрэл	"Монголын нууц товчоо", "Их хаадын үндэслэсэн үндэсний их шар тууж оршибай" зохиолуудын уран дүрслэл
2007-2008			
2	2	Бямбасүрэн.Э	“Баянжанжины шүлгийн онцлог”
2008-2009			
2	3	Болор-Эрдэнэ.Ш	“Инжаннашийн “Хөх судар” хоймсон роман дахь “толь тайлах” хэмээхийн учир

2	4	Отгонзул.М	“Аман болон бичгийн уран зохиол дахь Амарсанаагийн дүрийн онцлог”
2010-2011			
2	5	Хишигдэлгэр.Б	“Чингисийн хоёр эр загалын тууж оршибай” зохиол адгуусны туультай холбогдох нь
2014-2015			
2	6	Төмөрдулам.Т	Сэдэв: “Солиот хэмээн алдаршсан Шагдарын монголын уран зохиолын хөгжил дэх байр суурь”
2	7	Жаргалмаа.Б	“Инжаннашийн зохиол дахь дүрийн бэлгэ шинж, уран зохиол, түүхэнд холбогдох нь” / “Нэгэн давхар асар”, “Улаанаа ухилах танхим” хоймсон романы жишээн дээр/
2	8	Хүсэлбаяр.Ч	“МНТ дах үхэр, тэмээний дүрслэл, утга учир”


3. Орчин үеийн уран зохиол

Орчин үеийн уран зохиолын судалгааг үечлэлээр авч үзвэл 66,6 хувь буюу 2/3 нь монголын уран зохиолын хөгжлийн төлөвшлийн үе болох 1948-1987 оны гол төлөөлөгчид хийгээд бүтээл туурвилд тулгуурласан бөгөөд 1937-1948 оны буюу их хэлмэгдүүлэлтийн дараах он жилүүдийн судалгаа хийгдээгүй аж. 1937 оноос өмнөх болоод 1987 оноос хойших судалгаа зохих төвшинд хийгджээ.




4. Сэтгүүл зүй

Сэтгүүл зүйн хувьд бичлэгийн төрөл зүйл болох сурвалжилга, найруулга, эсээ, тэмдэглэл болоод сэтгүүлчийн ёс зүйн асуудлыг хөндсөн ажил зонхилж байгаа бөгөөд хэвлэл мэдээллийн хэрэгслийн хэл найруулгын асуудал судалгааны ажлын 50 хувийг эзэлж байна.



Бакалаврын судалгааны ажил нь сургалтын төлөвлөгөөтэйгөө нягт холбоотой. 2006-2016 онд утга зохиол судлал хөтөлбөрийн бакалаврын сургалтын төлөвлөгөө нийт таван удаа өөрчлөгдөн батлагджээ. Анх утга зохиолын судлал ангийг нээхэд 4 жилд 128 багц цаг судалж байсны 100 багц цаг нь мэргэжлийн хичээл байсан бол хамгийн сүүлд 2015 онд батлагдсан хөтөлбөрт нийт 120 багц цаг биелүүлэхээс 84 багц цаг болон багасаж мэргэжлийн хичээл 16 багц цагаар хасагджээ. Энэхүү танагдсан хичээлд Төвд хэл, монгол бичиг зэрэг хичээлүүд орсон нь XX зууны эхнээс өмнөх сурвалж, эх бичвэрүүдийг үзэж судлахад хүндрэл учруулж буйгаас энэ чиглэлийн судалгаа хийгдэхгүй байна.

Утга зохиол судлал хөтөлбөр /2006-2016/



ДҮГНЭЛТ

Утга зохиол судлал хөтөлбөрийн бакалаврын түвшинд аман зохиол, орчин үеийн уран зохиолын судалгаа голлон хийгдэж буй бөгөөд сүүлийн жилүүдэд сэтгүүл зүйн чиглэлээр дипломын ажил бичих нь харьцангуй ихэссэн байна. Мөн сургалтын төлөвлөгөөнд сурвалжийн хэлний хичээл ороогүй нь эртний уран зохиолын чиглэлээр судалгаа хийгдэхгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна үзэх үндэстэй.

SUMMARY

A study of contemporary literature and folklore is mainly studied by students of undergraduate literature program. However, a number of bachelor diploma on journalism has increased well in recent years.

As a result of a course of primary source study is not included in the curricula, students are could not attend in class of the ancient literature.